



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/7298

Улаанбаатар хот

Татан буулгах комисс
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Иргэний хуулийн 32 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 123 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор барилгын ашиглалтын өмнөх захиргаа” ОНӨТҮГ-ыг татан буулгах үүрэг бүхий Комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар байгуулж, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

1.1.байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж, хаалтын тайлан гарган, холбогдох байгууллагад хүлээлгэн өгөх;

1.2.татан буулгаж байгаа тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, иргэн аж ахуйн нэгж, байгууллагуудтай холбогдох өр авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах;

1.3.байгууллагын баримт бичгийг холбогдох журмын дагуу Нийслэлийн Нийслэлийн Архивын газарт шилжүүлэх ажлыг зохих журмын дагуу зохион байгуулах;

1.4.Хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасуулах.

2.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (П.Хадбаатар)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110205733

Нийслэлийн Засаг даргын 2024 оны
...~~27~~ дугаар... сарын ...~~04~~ өдрийн
~~А/22.9.8~~ дугаар... захирамжийн
хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга

Гишүүд:

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга;

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын Гэрээ, эрх зүйн хэлтсийн дарга;

- Нийслэлийн Архивын газрын дарга;

- Нийслэлийн Дотоод аудитын албаны дарга;

- “Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор барилгын ашиглалтын өмнөх захиргаа” ОНӨТҮГ-ын дарга;

Нарийн бичгийн дарга:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газрын Хүний нөөцийн хөгжлийн хэлтсийн дарга.